

Авто инженер хөтөлбөр

Хөтөлбөрөөр олгох мэдлэг, эзэмших ур чадвар

Автомашин ашиглалт, авто аж ахуй мэргэжлийн чиглэлээр төгсөгч нь эзэмшсэн мэргэжлийн дагуу тодорхой салбаруудад ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн ашиглалт, үйлчилгээг хариуцах, эрдэм шинжилгээ, зохион бүтээх ба удирдан зохион байгуулах /автомашин, түүний агрегат системүүдийн бүтэц, ажиллагаа, ашиглалт, засварын тоног төхөөрөмжийн гэмтэл саатлыг илрүүлэх, оношлох, засварлах, хэмжилт тохиргоо хийх, аливаа хийцийн тоног төхөөрөмжийн зураг дүрслэлийг зурах, уншиж ойлгох ашиглах/ чадваруудыг эзэмшсэн авто тээврийн инженер болно.

Мэргэжлийн зориулалт

Автомашинны техникийн үйлчилгээ, засварын газруудад механикч инженерээр ажиллах, тээвэр болон замын хөдөлгөөн зохион байгуулах байгууллагууд, төр захиргааны байгууллагуудад ажиллах.

Мэргэжилтний мэдлэг, чадвар, дадал, хандлага

Автомашинны зохион байгуулалт, бүтэц, үйл ажиллагаа болон түүний ашиглалтын талаарх өргөн мэдлэгтэй, автомашинд техникийн үйлчилгээ, засварыг технологийн дагуу хийх, автомашинны оношлогооны болон засвар, үйлчилгээний тоног төхөөрөмжийг ашиглах, авто үйлчилгээний газрын төсөл зохиох, замын хөдөлгөөний нөхцөлтэй уялдуулан замын хөдөлгөөнийг осолгүй зохион байгуулах зэрэг чадварыг эзэмшсэн байна.

Мэргэжилтэнд тавигдах нийтлэг шаардлага

Мэргэжилтэн нь тухайн мэргэжлийн хүрээнд тулгарсан асуудлыг мэдэрч шийдвэрлэн хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцдог бүтээлч, хамтач, үйлчилгээний соёлтой, мэргэжилээ бие даан дэвшүүлэн сурч чаддаг, үнэнч шударга, зарчимч байх шаардлагатай.

Ажлын байр

- Автомашинны засвар, үйлчилгээ эрхэлдэг бүх төрлийн байгууллага, компаниуд, уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд /Оюу толгой, Таван толгой, Эрдэнэт үйлдвэр / гэх мэт
- Автотээврийн үндэсний төв;
- Зорчигч тээврийн нэгтгэл болон бусад тээврийн байгууллагууд;
- Автомашинны дистрибьютер компаниуд /Тоёота, МСМ, Хьюндай/
- Барилга, замын компаниуд;
- Замын цагдаагийн газар, батлан хамгаалах салбар зэрэг хүчний байгууллагууд;

Автомашинтай холбоотой мэргэжилтэн бэлтгэдэг сургууль, курс, судалгаа шинжилгээний байгууллагуудад ажиллах боломжтой